



Д.НЯМТУЛГА
ХСИС-ийн Шүүхийн
шийдвэр гүйцэтгэлийн
сургуулийн Шийдвэр
гүйцэтгэлийн
тэнхимийн багш,
дэслэгч



О.ОДБАЯР
ШШГЕГ-ын харъяа
Баянхонгор аймаг дахь
Шүүхийн шийдвэр
гүйцэтгэх албаны
төлөөлөгч, дэслэгч

ХОРИХ АНГИЙН ЭКОЛОГИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЗАРИМ АСУУДАЛ

Хураангуй: Экологи гэх асуудал нь байгалийн тэнцэл, амьд болон амьгүй организм¹ гээд маш олон янзаар ойлгох нь бий. Гэхдээ нөгөө талаас уг ойлголтыг шууд хүний эрүүл мэндтэй холбон тайлбарладаг. Хорих байгууллага, экологи хэмээх ойлголтуудыг хооронд нь хоршуулж “Хорих байгууллагын экологи”-ийн асуудлыг судлахын ач холбогдол, цаашлаад хүний эрхийг дээдлэгч Монгол Улсын өнөөгийн байдалд хорих ангид ял эдлэгсдийн эрхийг хангахад дээрх асуудал хэрхэн нөлөөлж буйг тодорхойлох.

¹Э.Батбаяр “Экологийн эрх зүй”, 1998 он., УБ хот., 18 дахь тал.

Түлхүүр үгс: Үндэсний аюулгүй байдал, хорих байгууллага, экологийн тэнцвэрт хөгжил, хүний эрх, эрх чөлөө, эрүүл мэнд, ялтан, алба хаагч, ногоон орчин, ялтны амьдралын бүс.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 1.1.2: “Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхолд Монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэр, хил хязгаарын халдашгүй байдал болон бүрэн бүтэн байдал, үндэсний эв нэгдэл, үндсэн хуульт байгууллын аюулгүй байдал, эдийн засгийн бие даасан байдал, *экологийн тэнцвэрт хөгжил багтана*² хэмээн тусгаж өгсөн байна. Хорих ангид тодорхой эрхээ хязгаарлуулсан “хүн” хоригддог. Мөн “хүн” ажилладаг. Аль нэг хилийн дээс, барилга байгууламжаас үл хамаарах агаар гэх зүйлээр хүн бүр амьсгалж, хөрсөн дээр гишгэж экологи гэх ойлголттой салшгүй хамааралтай явдаг. Хүний эрх, эрх чөлөөний төлөөх тэмцэлд анхаарал татсаар ирсэн нэгэн зүйл бол хорих байгууллага дахь ял эдлэгсдийн эрхийн асуудал, тэдгээрийн орчин нөхцөл, ахуй гэж тодорхойлж болох юм.

Ялтан бол иргэн. Зарим эрхээ хязгаарлуулсан ч “Монгол Улсын

Үндсэн Хууль”³-ийн 16-р зүйлийн 16.1.2 дахь заалтад: Монгол улсын “Эрүүл, аюулгүй орчинд амьдрах” эрхтэйг тусгасан байна. Ялтны амьдралын бүс нь жирийн иргэдийн амьдрах орчныг бодвол аливаа төрлийн агаар дуслын замаар дамжин халдварлах өвчин үүсэх магадлал тун өндөр. Тиймээс хорих ангид эко орчныг бүрдүүлэх асуудал шаардлагатай байгааг дурьдагдах судалгаанаас харж болно.

Хорих байгууллага ба экологи

Экологи гэдэг нь эко буюу орон зай, логи буюу орчноо судлах гэсэн үгнүүдээс гаралтай. Энэхүү нэр томъёог анх 1886 онд Германы эрдэмтэн А.Гекель гаргаж иржээ. Тэр “Экологи бол байгалийн тэнцвэрийн тухай ойлголт бөгөөд амьд бие ба түүний хүрээлэн буй орчны органик, органик бус бүрэлдэхүүн хэсгийн хоорондын харилцан хамаарлын тухай шинжлэх ухаан”⁴ юм гэж тодорхойлжээ. Гэхдээ өнөөдөр экологи гэдэг ойлголт нь зөвхөн байгаль орчны асуудал биш хүний амьдрах орчны бүхий л асуудлыг судалдаг өргөн хүрээний ойлголт болжээ.

Эрүүл байх нь хүний амьдралын хамгийн үнэ цэнэтэй зүйл, нийтийн нөөц баялаг мөн

бөгөөд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын тодорхойлсноор “Эрүүл мэнд” бол амьдралын чанарын тусгал бөгөөд зөвхөн өвчингүй байхаас хамаагүй өргөн хүрээний ойлголт юм⁵ гэж тодорхойлсон байдаг.

Иймээс хүний амьдрах орчинд гарч байгаа өөрчлөлтийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн ашигтай талыг давуу байлгах, орчны сөрөг нөлөөллийг тодорхой хэмжээнд багасгах хэрэгцээ шаардлагатай бөгөөд өнөөдрийн тулгамдсан асуудлын нэг болж байна.

Экологи өнөөдөр зөвхөн биологийн шинжлэх ухааны нэг салбар төдийгүй байгаль, нийгмийн асуудлыг хамарсан нэгдмэл шинжлэх ухаан болсон байна. Нийгмийн үнэт зүйл, нийгмийг бүрдүүлэгч эд, эс бол хүн. Иймээс энэ салбар шинжлэх ухаан нь хүнтэй холбоотой нь харагдаж байна. Хүн байгаль хоёр хүйн холбоотой гэдэг, хорих байгууллага /хорих анги/-д хүн хоригдоно. Иймээс тухайн хорих байгууллага нь хүнийг хүрээлэн буй орчин нөхцөлтэй нь харьцах харьцааг бий болгох шаардлага гардаг.

Экологи нь дараах салбаруудтай:

1. Ургамлын экологи
2. Амьтны экологи
3. Бичил биетний экологи

² Монгол Улсын Их Хурлын тогтоол., 2010 оны 07 сарын 15 өдөр., УБ хот., дугаар 48

³ Төрийн мэдээлэл сэтгүүл., 1992 он., №1.

⁴ Ж.Нямхүрэл., Экологи., УБ хот., 2005 он., 5 дахь тал.

4. ХАА-н экологи
5. Үйлдвэрийн экологи
6. Хүний экологи

Үүнээс судалгааны салбар нь “Хүний экологи” юм. Хорих ангид ял эдэлж байгаа ялтны орчин буюу байгалийн нар, салхи, чийг, цэвэр агаар гэх мэт асуудлуудыг ойлгож болно. Нөгөө талаас хорих ял эдэлж байгаа ялтнууд нь нийгэмд гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүй хийснээр шийтгэгдэж хууль ёсны хүрээнд зарим нэг эрхээ хязгаарлуулсан боловч тэдэнд Монгол Улсын Үндсэн хууль болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан эрхээ эдлэх боломжийг бүрдүүлж өгөх нь зүйтэй юм. Үндсэн хуулийн 16-р зүйл: 16.2 “Монгол улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй”, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 115-р зүйл: 115.1.10 “Ялтан хувийн аюулгүй байдлаа хамгаалуулах эрхтэй”... гэсэн хэм хэмжээг хангуулахад хорих байгууллагын экологи гэсэн ойлголтын хүрээнд ямар нэгэн арга хэмжээг Монголын төрийг төлөөлж ял эдлүүлэх ажиллагааг явуулдаг, ялтны эрхийг хангах үүрэг бүхий байгууллагын хувьд энэ тал дээр тодорхой үйл ажиллагаа явуулах нь зүйтэй.

Хорих байгууллагын экологийн тухай ойлголтыг цаашид нарийвчлан авч үзвэл ялтны амьдралын бүс болон хориотой бүс дахь хүрээлэн байгаа орчныг бохирдлоос хамгаалах, улмаар хүн төрөлхтний байгальтайгаа шүтэлцэн амьдрах онолын үндсийг тодорхойлоход агуулга оршино. Мөн хорих ангийн хориотой бүс болон ялтны амьдралын бүсээс гадна байгалийн нөөц баялагтай холбогдон гарах олон төрлийн харилцаа байдаг.

Жишээлбэл: Аж ахуй, үйлчилгээнд ажиллаж буй ялтнууд, тэдгээрийг хянах алба хаагчдаар илэрч болох юм. Мөн хорих ангийн үйлдвэрлэлтэй холбоотой байгалийн баялгийг ашиглах харилцаа ч байдаг. Байгалийн баялгийг ашиглах талаар Монголын хорих байгууллага арвин их туршлага түүхтэй бөгөөд түүхэн эх сурвалжаас харахад төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед хорих ангийн үйлдвэрлэл мод, зүсмэл материал үйлдвэрлэж байгалийн баялгийг ашиглаж байсан. Энэ үед нөхөн сэргээлтийн үйл ажиллагааг эрчимтэй явуулж байсан.⁶

Модны үйлдвэрлэл явуулдаг хорих ангид ойн инженер, үржүүлгийн хэсэг салбар ч ажиллаж байсан. Тэд дан ганц байгалийн баялгийг ашиглаж байгаагүй бөгөөд

чиг хандлага

⁶ А.Лхагваа, Гяндан салаанаас ШШГЕГ болж өргөжсөн түүхэн замнал., 2011 он. УБ хот., 120 дахь тал

⁵ [www.monkey.mn/Дэлхийн эрүүл мэндийн](http://www.monkey.mn/Дэлхийн_эрүүл_мэндийн)

байгаль хамгаалах үйл ажиллагаанд үнэтэй хувь нэмэр оруулж байсан нь түүхэн эх сурвалжаас харагдаж байна.

Жишээлбэл: Ард иргэдийн тавьсан ойн түймрийг унтрааж улс орны аюулгүй байдалд үнэтэй хувь нэмэр оруулж байв.

Хорих байгууллагын

экологийн өнөөгийн байдал

Монгол Улсын хэмжээнд 2017 оны 03 дугаар сарын байдлаар 25 хорих ангид 5400 гаруй ялтан хорих ял эдэлж байна⁷. Дээрхи 25 хорих ангиас сонгож 2 хорих ангид экологийн талаарх судалгааг явуулсан. Үүнд: Судалгааны явцад ШШГЕГ-аас хорих ангиудад эрсдлийн үнэлгээ хийгдсэн байгаа боловч “Хорих байгууллагын экологи”-ийн орчинд хийсэн судалгаа байхгүй, энэ талын судалгаа хийгдээгүй байсан. Тухайн төсөөллийг бататгахын тулд ШШГЕГ-ын харьяа Хорих 405, 415 дугаар ангийг сонгон авч ялтны амьдралын бүсийн зургийг судлан ажиглах аргаар ялтны амьдралын бүс дэх экологийн орчинг тогтоохыг оролдсон.

Хорих 415 дугаар ангид 400 орчим ялтан хоригдож байна. Тус хорих анги нь тал хээрийн бүсэд байдаг бөгөөд хөрсний хувьд элсэрхэг, ундны ус нь шохой, давс илэрдэг зэрэг байгалийн онцлог

харагдаж байлаа. Хорих 415 дугаар ангийн ялтны амьдралын бүс дэх зургаас харахад зуны улиралд хүний харагдах ил хэсэгт цэцэг тарьж экологийн тогтцыг бүрдүүлдэг байна. Энэ нь улирлын чанартай үйл ажиллагаа юм.



Тус хорих ангид хоригдож буй нийт ялтны 50 гаруй нь шохой боловсруулах үйлдвэрт ажилладаг /Улирлын чанартай/. Ялтнуудын дийлэнх нь төдийгүй тэднийг хянаж буй алба хаагч нар амьсгалын замын өвчин /астам/ туссан байдаг. Гэтэл ногоон байгууламж нь хуурай бохир агаарыг өөртөө шингээн авч цэвэр агаар үүсгэдэг онцлогтой. Иймээс эко орчныг хорих ангид бүрдүүлэх зайлшгүй шаардлага тулгардаг.

Хорих 405 дугаар ангид 80 гаруй ялтан хоригдож байна. Тус хорих анги нь Таширын аманд байрладаг бөгөөд газар нутгийн хувьд уулархаг, хар хөрстэй, байгалийн ногоон орчин бүрэлдсэн, дээр дурьдсан хорих ангиудыг

⁷ ШШГЕГ-н нэгдсэн тоо бүртгэл, судалгаа, дүн шинжилгээний тасгийн судалгаанаас

бодвол эко орчин хэвийн хэмжээтэй байдаг. Харин гянданд ял эдлүүлэх үйл ажиллагааг гяндангийн байранд ялтны хөдөлгөөнийг хязгаарлан явуулдгаараа онцлогтой.

Иймд эко орчинг гяндангийн байранд харуул хамгаалалтын аюулгүй байдлыг ханган бүрдүүлэх боломжтой. Тасалгааны цэцэг, ургамал тарих г.м.



Дээрхи зурган дээрээс Хорих 405, 415 дугаар ангийн гадна орчныг харуулсан. Тус хорих ангиуд нь харагдах байдлын хувьд зүлэг ногоо ургасан ногоон орчин бий болсон боловч эко орчныг улам боловсронгуй болгон олон улсын болон стандартад нийцсэн орчинг бүрдүүлэх шаардлагатай юм. Энэ мэтчилэн тодорхой стандартын дагуу ногоон байгууламж бий болгох нь үндсэн хуульд болон бусад хууль тогтоомжид заасан ялтны эрхийг хангахад чиглэгдсэн арга хэмжээ юм.

Өнөөгийн хорих ангиудад хүний эрх, эрх чөлөөг хангах үүднээс ялтан этгээдийн ахуй нөхцлийн талаарх асуудлыг хөндөж тавьдаг боловч тухайн ялтны ахуйн хүрэн дэх тэр дундаа хүрээлэн буй орчин,

ногоон бүс, ногоон байгууламжийн талаар авч үзээгүй нь хорих байгууллагын хэмжээнд тулгамдаж буй асуудал гэж үзэхэд болохоор байна.

Дүгнэлт

Экологийн асуудал нь хорих ангид тулгамдсан асуудал болсноор түүнийг нэн даруй шийдвэрлэх шаардлагыг бий болгож байна.

Экологийн асуудалд:

1. Ялтны болон алба хаагчийн эрүүл мэнд
2. Амьдрах тав тух
3. Хориотой бүсийн аюулгүй байдлыг хангах тал дээр хэрхэн холбогдох зэрэг асуудлуудыг шийдвэрлэх арга замыг олох юм.

Хорих ангид сэтгэл заслын өрөө гэж байдаг. Энэ нь нэг талаас л ялтны сэтгэл санааг засах, амраах, тогтворжуулах гэсэн зорилготой байдаг. Ийм орчинд сэтгэл заслын үйл ажиллагаа явуулахаас гадна хорих ангид амьд орчин бүрдүүлж /өвс ногоо, цэцэг, усны урсгал буюу бяцхан булаг горхи бүрдүүлэх/ ялтны сэтгэл заслын орчинг өөр өнцгөөс бий болгох нь ач холбогдолтойг гадны орны туршлагаас харж болохоор байна. Энэ нь мөн тухайн хорих ангийн алба хаагчдад ч эергээр нөлөөлөх юм. Алба хаагчид нь ажлын байр дээрээ ихэвчлэн стрессийн байдалд

орсон байдаг гэсэн судалгаа бий. Усны чимээ нь хүний уур бухимдлыг тайлж ядаргааг арилгадаг. Мөн ялтан болон алба хаагчийн уух усны хатуулаг, агаарын чийгшилт, нарны гэрэл зэрэг ахуй нөхцлийн асуудлууд бий.



Хорих ангийн ялтны амьдрах орчин нөхцөл дээрх зургийн дагуу байх ёстой боловч гадна орчин мөн энэ мэт тор, цементээр битүү хучигдсан байх нь учир дутагдалтай. Тиймээс ялтнуудын амьдралын бүс болон үйлдвэрлэлийн бүс нь ногоон байгууламж бүхий байх нь тал талаасаа ач холбогдолтой боловч харуул хамгаалалтын хэвийн ажиллагааг алдагдуулахуйц байж болохгүй.

Аливаа улсын Нийслэлийн 90 хувь нь ногоон байгууламж байна гэсэн олон улсын стандарт байдаг. Гэтэл манай улсын Нийслэл Улаанбаатар хотын ердөө 5 хувь нь ногоон байгууламж байдаг гэсэн харамсалтай тоо байна.

Ногоон байгууламж нь хүчилтөрөгч ялгаруулж, нүүрсхүчлийн хийг өөртөө шингээн агаар цэвэршүүлж, агаарын бохирдлыг бууруулдаг сайн талтай.

Ногоон байгууламжийг макро түвшин байгуулж чадахгүй байгаа ч микро түвшинд буюу хорих анги дотор бий болгох бүрэн боломжтой юм. Ингэснээр улс орны нийт хүн амын эрүүл мэндийг хамгаалах боломжгүй ч хэсэг бүлгийн буюу ялтан болон алба хаагчдын эрүүл мэндэд анхаарал хандуулах алхам болох юм.

Санал

1. Ялтанд экологийн боловсрол олгох.

Хорих ангийн дотоод журам 14.2: “Жирийн дэглэмтэй хорих ангийн ялтан ялынхаа хоёрны нэгээс доошгүйг эдэлсэн, сахилгын зөрчил гаргаж байгаагүй бөгөөд их, дээд сургууль, коллежид эчнээгээр суралцах хүсэлт гаргасныг хорих ангийн дарга дэмжсэн бол Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга ийнхүү суралцахыг зөвшөөрсөн тушаал гаргана.” гэх заалтыг 14.2-оор дэлгэрүүлж

“Эчнээгээр суралцах мэргэжил нь байгаль хамгаалах, экологийн чиглэлтэй байж, хорих ангийн бүс дахь экологийн асуудалд хувь нэмэр оруулахуйц суралцаж байгаа ялтныг хорих ангийн дарга эрхийн хүрээнд дэмжин урамшуулах” гэж нэмэх.

2. Ялтны сэтгэл заслын орчинг амьдралын бүсэд бодитоор бүрдүүлэх.

Ялтан зөвхөн хорих ангийн сэтгэл зүйчийн өрөөнд бус хорих ангийн хашаан дотроос сэтгэл заслыг авч чадвал ялтны дундаас үүсэх гэмт хэрэг, зөрчлийн тоо багасах төдийгүй сэтгэл гутралаас үүсэх өвчлөл, хямрал багасах ач холбогдолтой.

3. Ялтанд хөдөлмөрийн дадал, чадвар олгох ажлын хүрээнд мэргэжлийн цэцэрлэгч, үрсэлгээчин бэлтгэх

4. “Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийх төсөл”-д хорих ангийн байгаль орчин гэсэн ойлголт байхгүй байгаа нь уг асуудлыг шийдвэрлэхэд энэ талаар хууль болон дүрэм журамд тусгаж өгөх шаардлагыг агуулж байна. Тиймээс “Хорих анги ба экологи” гэх ойлголтыг гаргаж ирснээр дараах асуудлыг эергээр бий болгох боломжтой./Эрүүл аюулгүй амьдрах орчин, эрүүл мэнд, хүний эрх эрх чөлөө, сэтгэл зүйн тогтвортой байдал, хандлага/... гэх мэт.

Эх сурвалжийн жагсаалт

Хууль тогтоомж:

1. Монгол улсын үндсэн хууль. 1992 он
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. 2002 он
3. Байгаль орчныг хамгаалах тухай хууль. 1995 он
4. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай. 2012 он
5. Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийх төсөл

Ном зохиол, сурах бичиг:

1. Л.Түвдэн “Хүний эрх” УБ хот., 2010 он
2. А.Элдэв-Очир “Хүний эрхийн хөндөгдөж буй асуудлууд” УБ., 2002 он
3. Б.Батболд “Экологи ба ахуй орчин” УБ хот., 1999 он
4. Ж.Нямхүрэл “Экологи” УБ хот., 2005 он
5. А.Лхагва “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй” УБ хот., 2011 он
6. Э.Батбаяр “Экологийн эрх зүй” УБ хот. 1998 он
7. А.Лхагваа “Гяндан салаанаас ШШГЕГ болж өргөжсөн түүхэн замнал” УБ хот. 2011 он.